МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 24 өдөр Дугаар 287 Улаанбаатар хот

"Монголын гэгээ" ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 22 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын гэгээ" ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 271,805 /хоёр зуун далан нэгэн мянга найман зуун тав/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг "Монголын хөрөнгийн бирж" ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг "ҮЦТТТХТ" ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулж өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг 3,457 /гурван мянга дөрвөн зуун тавин долоо/ төгрөгөөр тооцон холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн ажлыг 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнахыг "Монголын гэгээ" ХК /Г.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Компанийн тухай хуулийн 24.4-т заасан журмын дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг хэрэгжүүлэхийг "Монголын гэгээ" ХК /Г.Отгонбаяр/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА З.НАРАНТУЯА

000879